

2021 он 03 сар 19 өдөр

Дугаар 21/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн хурал  
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Е-Моние” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цагт цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 9-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2021 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.



6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.

7. Хурлын даргаар "Ард Санхүүгийн Нэгдэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуягийг томилсугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

"Ард Менежмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа

Хурал байгуулах комиссын гишүүд:

"Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн Хуулийн зөвлөх Ө.Ашхүү;

"Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн нягтлан бодогч Х.Цэрэннадмид;

"Ард Менежмент ҮЦК" ХХК-ийн санхүүгийн шинжээч

Ч.Хандсүрэн.

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийн Г.Алтансүх;

Тооллогын комиссын гишүүд:

"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийн Б.Ариунзул;

"Блүмсбюри секьюритис ҮЦК" ХХК-ийн Д.Мөнчанар.

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Хандаад даалгасугай.

ДАРГА



Ш.БАТЖАРГАЛ